

АГУУЛГА

ОРШИЛ.....	2
НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ	12
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	15
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
4.1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө... 17	
4.1.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
4.1.3. Хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19
4.1.4. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	20
4.1.5. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	21
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	22
4.3. Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	23
4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
4.6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	24
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
4.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	29
4.10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	29
4.11. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардал.....	30

ОРШИЛ

“Ориент” ХХК-ийн Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших “Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”-ийн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖЯ-наас 2019 оны 10 дугаар сарын 29- ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд төлөвлөлтийг тус журмын 1 дүгээр хавсралтын “А”-д заасан агуулгаар боловсруулсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан. Тус ордын ТЭЗҮ нь 2025 оны 12-р сард батлагдан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ нь 2026 оны 4-р сард батлагдсан. Чигэртэй ордын уурхайн ашиглалтын эхний жил 2026 он ба тус оны уулын ажлын төлөвлөлт төслийн үйл ажиллагаатай уялдуулан БОМТ-г боловсрууллаа.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 25,860,000 төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төлөвлөгөөний нэр: “ Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэрийн төсөл”-ийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Ориент” ХХК

Төслийн зорилго: “ Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэрийн төсөл ” нь зэс алтны үндсэн ордыг ашиглалт олборлолт явуулах, хүдрийг баяжуулан зэс алт олборлох, ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэнд оруулах үндсэн зорилготой.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга


№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Ориент” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9011838704
3	Уурхайн нэр		Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэрийн төсөл
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Баян-Өлгий
5		Сум/Дүүрэг	Дэлүүн
6	Ашигт малтмалын төрөл		Зэс, Алт
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-023068
8	Ашиглалт эхэлсэн огноо		2026
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
10		Сум/Дүүрэг	Сүхбаатар,
11		Баг/Хороо	3-р хороо
12		Гудамж/Байр	Сөүлийн гудамж, Браухаус төв 306 тоот
13		Гар утас	99082810
14	Захирлын хаяг	Нэр	Гүйцэтгэх захирал Д.Даяндэмэд
15		Гар утас	99082810
16		Электрон шуудан	dalaidayanaa@yahoo.com

Төслийн байршил: “Чигэртэй зэс алтны” орд нь Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутаг дэвсгэрт байрладаг.

- Засаг захиргаа: Баян-Өлгий аймаг, Дэлүүн сум,
- Ордын нэр: " Чигэртэй нэртэй зэс алтны орд "
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Зэс, алт
- Трапецийн номенклатур: L-46-2
- Талбайн нийт хэмжээ: 3957.72 га

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн хилийн солбицол

№	Газарзүйн солбицол					
	Уртраг			Өргөрөг		
1	90	33	28.1	47	54	13
2	90	30	0	47	54	13
3	90	30	0	47	58	0
4	90	34	45	47	58	0
5	90	34	45	47	55	29.9



Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг



Зураг 2. Чигэртэй уурхайн төсөл хэрэгжих талбайн байгалийн үндсэн төрх

Орд ашиглах тусгай зөвшөөрөл: Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших 3,957.72 гектар талбай бүхий, Чигэртэй талбайн зэс-алтны ордын MV-023068 тоот тусгай зөвшөөрлийг АМГТГ кадастрын албанаас 2025 оны 08 сарын 26-ны өдөр 30 жилийн хугацаатайгаар авсан байна.

Уурхайн одоогийн байдал: “Ориент” ХХК нь Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг 2025 онд батлуулсан ба уурхайлалтын ажлыг 2026 оноос эхлэхээр төлөвлөн ажиллаж байна. Төслийн талбайд баяжуулах үйлдвэрийг барилгын ажил 2025 оны 7-р сараас хийгдэж эхлээд байна.

Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц: Нийт ордын хэмжээнд хайгуулын шугам хоорондын зай нөөцийн тооцооллыг С зэрэглэлийн нөөцийн 7 хүдрийн биетийн онцлог нь энгийн тогтоцтой, зүүн урдаас баруун хойш чиглэлд сунасан, зүүн урагш 325-345 градусын чиглэлд, зүүн урагш 68-88 хэмийн налуу байрлалтай, хоорондоо салангид орших хэвтэш хэлбэрийн биетүүдээс бүрдэнэ. Тус хүдрийн биетүүдэд зэсийн агуулга 0.1-6.62%-ийн хороонд илэрсэн. Дундаж агуулга нь 0.35% байна.

Төслийн хүчин чадал: Ашиглалтын нийт хугацаанд Чигэртэй ордын уурхайгаас зэсийн дундаж агуулга 0.81%-тай 1.74 сая.тн хүдрийг ил болон далд аргаар олборлоно. Үүнд: Уг төсөлд баяжуулах үйлдвэрийн технологиос гарах эцсийн бүтээгдэхүүн нь зэс, алтны хам баяжмал байна. Ашиглалтын нийт хугацаанд хүдэр баяжуулах үйлдвэр MNS 5717:2007 стандартын 2-р зэрэглэлийн 64.94 мян.тн зэс, алтны хам баяжмал үйлдвэрлэнэ. Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ВАХТ-ын системээр ажиллах ба хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Тэсэлгээний ажил: Тэсэлгээний ажилд дотоодод үйлдвэрлэж буй энгийн найрлагат “ANFO” найрлагат тэсрэх бодис, мөн эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. Тэсэлгээг **14 хоногт нэг удаа** хийх

ба тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу аюулгүй байдлыг дээд зэргээр хангасны үндсэн дээр ерөмдлөг-тэсэлгээний ажлыг мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээлэн гүйцэтгүүлнэ.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүй: Чигэртэй талбай нь Монгол орны хөрс био уур амьсгалын мужлалаар Төв Азийн мужийн Говийн дэд мужид, бүсшилийн хэв шинжээр Говийн мужийн Говь-Алтайн тойрогт багтана. Цаг уурын бүсчлэлийн хувьд Алтайн Өвөр говийн цөлөрхөг мужийн хойд хэсэгт байрлана. Цаг агаар нь зуны улиралд хуурай халуун, хур тунадас бага унадаг, хавар намрын цагт хүчтэй шуурга салхитай харин өвлийн улиралд цас орох нь ховор байдаг бөгөөд Монголын хойд хэсгээс харьцангуй дулаахан өвөл болдог онцлогтой газар юм.

Уул зүй: Тусгай зөвшөөрөлтэй талбай нь уул зүйн хувьд Монгол Алтайн нурууны өндөр уулсын бүсэд багтдаг. Хамгийн нам дор газар нь Буянт голын хөндийд 1478-2024 м байдаг бол, өндөр уулсын бүсэд багтах Тахилт нуруу 4019 м, Бүргэдийн уул 3776 м, Хүйтэн салаа уул 3576 м, Улаагчин уул 3710 м, Агуйт нуруу 3589 м уул нурууд болно.

Талбайн 30% нь өндөр уулсын районд дундаж өндөр нь 3000м-ээс дээш, 50% нь дунд уулархаг мужид 2000-3000 м, үлдсэн хэсэг нь намхавтар уулсын мужид 1500-2000 м хамаарна. Уулууд нь эгц хажуутай элэгдлийн хөндийнүүдээр тусгаарлагдах ба уулсын харьцангуй өндөр нь уулсын районд 1500-2000 м, дунд уулархаг мужид 1000-1500 м-ийн хооронд хэлбэлзэнэ. Уул нурууд нь хоорондоо элэгдэл хуримтлалын хөндий, олон тооны том жижиг нуур бүхий уулс хоорондын хотгор, хөндийнүүдээр хязгаарлагдсан байдаг. Эдгээр хотгор хөндийнүүдийн хэмжээнд долгиолог, толгодорхог, эсвэл 30-60 м өндөр дэнж маягийн гадарга үүсгэж мөстлөгийн хурдас тархсан байдаг.

Уур амьсгал, агаарын чанар: Чигэртэй талбай нь эрс тэс уур амьсгалтай нэлээд удаан үргэлжлэх хүйтэн өвөлтэй, богинохон сэрүүн зунтай, агаарын хэм нь жилийн туршид байнга хэлбэлзэлтэй, хур тунадас их унадаг уулын бүсэд оршино. Баян-Өлгий аймгийн цаг уурын станцын судалгаагаар жилийн туршид унах хур тунадасны хэмжээ нь 105-155 мм орчим бөгөөд агаарын дундаж температур нь хамгийн хүйтэн байх 1-р сард -26.8С – 30С, хамгийн дулаан байх 7-р сард +20С хүрдэг ба бусад саруудад -10С - +15С хооронд хэлбэлздэг. Анхны цас 9-р сард заримдаа 8-р сарын сүүлээр орж эхэлдэг ба тогтмол цасан бүрхүүл 10-р сарын 2-р хагаст тогтдог. Салхи ихэвчлэн баруун хойноос салхилдаг.

Монгол Алтайн нурууны мөнх цэвдэгтэй бүсэд орших бөгөөд хөлдүү хөрсний улирлын гэсэлтийн гүн нь гипсометрийн өндөрлөгөөс шалтгаалж харилцан адилгүй байдаг бөгөөд 6-р сард хөлдүү хөрсний гэсэлтийн гүн нь голын хөндийд 2.0-5.0м хүрдэг.

Усан орчин: Талбайн хэмжээнд усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн ба олон тооны том, жижиг гол тэдний салбар горхинууд нь мөчирлөг хэлбэрийн систем үүсгэсэн байдаг. Талбайн хэмжээнд тархсан голууд нь мөнх цас хур тунадсаар тэжээгддэг гол, горхи, нуур, цөөрмүүд нь Төв Азийн гадагш гарах урсгалгүй ай савд багтана. Буянт голын ай савд багтдаг Чигэртэй, Рашаант, Дэлүүний голууд Монгол Алтайн хойд хэсгээс эх авч Буянт голтой нийлж, Хар-ус нуурт цутгадаг. Хамгийн том голууд нь Буянт, Булган, Цэнхэрийн гол бөгөөд Чигэртэй, Жингиз агачийн, Хүйтэн зэрэг дунд хэмжээний голууд маш олон байдаг бөгөөд эдгээр нь бүгд уулын түргэн урсгалт голууд юм. Эдгээр голуудын эрэг хөндий нь ихэнхдээ намгархаг болсон байдаг. Дээрх томоохон голуудын урт нь хэмжээнд 20-40 км, гольдролын өргөн нь 20-30 м орчим, гүн нь 0.5-1.5 м заримдаа 2.0 м хүрдэг. Эдгээр голуудын хөндийн өргөн нь 200-300 м, заримдаа 400-600 м, ховроор 2-4 км-ийн хооронд хэлбэлзэнэ. Томоохон голуудын хөндий нь ихэвчлэн “U” хэлбэртэй, тэдгээрийн эгц хажуутай салбар хөндийнүүд нь голдуу “V” хэлбэртэй бөгөөд аллюви, делюви-пролювийн


болон мөстлөгийн хурдсаар дүүргэгдсэн байна.

Уулс хоорондын жижиг хотгор тус бүр бие даасан шинжтэй ба тэдгээрийн эргэн тойронд ихэвчлэн түр зуурын үер борооны усаар тэжээгддэг хуурай сайрууд байх буюу заримдаа тогтмол устай, мөнх цас мөсний усаар тэжээгддэг гол горхиуд бий. Үүнд: Цагаан заримасны, Замтын гол зэрэг болно. Харин хамгийн том нь Улиастайн гол орно.

Тухайн дүүрэгт олон тооны цэнгэг устай нуурууд байдаг. Хамгийн том нь талбайн зүүн хойд хэсэгт орших Хар-Ус нуур бөгөөд Олгой нуур, Бөөрөлжийн хавцлын нуур, Битүүний Олгой нуур, Дуут зэрэг нуурууд орно. Мөн Дуут суманд Нэвтийн рашаан сувилал байдаг. Ихэнх тохиолдолд нуурын ус шорвог шинжтэй, заримдаа давс, хужир, шүү олборлоно.


Тус талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай урт хүйтэн өвөлтэй, богино сэрүүн зунтай. Байнгын цасан бүрхэвчтэй байдаг ба энэ бүрхүүл нь 9-р сараас эхлэн 5-р сарын сүүл хүртэл байна.

Хөрсөн бүрхэвч: Энэхүү бүлэгт Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Чигэртэй-1 нэртэй газар орших “Ориент” ХХК -ийн Чигэртэй нэртэй зэс-алтын орд газарт хийсэн хөрсний хээрийн болон лабораторийн шинжилгээний үр дүнг тусгав. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Говийн их мужийн Монгол Алтайн мужийн Монгол Алтайн тойрогт хамаарагдана (Монгол Улсын Үндэсний Атлас, 2022).



Ургамлан нөмрөг: Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт байрлах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Монгол-Алтайн уулын хээрийн тойрог-т хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Тус нутагт ургамалжлын өндөр уул таг цармын, уулын тайга, уулын хээр буюу уулын ойт хээрийн гэсэн үндсэн 3 бүслүүрийн ургамалжил тохиолдох онцлогтой Ургамлын хэв шинжийн зураглалаар / тус төслийн талбайн урд хэсгээр өндөр

уулын алагөвс, зогдор, улалж оролцсон ботууль бушилз оролцсон алаг өвст хэв шинж, талбайн дунд хэсгээр улалж бушилзтай /30%/ ботууль-агьт бүлгэмдэл, хойд хэсгээр дэр үүсгэсэн алаг өвс голлосон алаг өвс-ботууль-ерхөгт ургамлын хэв шинж илэрсэн байна.



Төслийн талбайн ургамалжилтын хэв шинж

Монгол Алтайн нурууны баруун хойд хэсгийн өндөр уулс нь Бушилзат, улалжит хүйтсэг нуга, хүйтсүү – хуурайсаг алаг өвс, жижиг дэгнүүлт хүйтсэг хээр болон хаг- хөвдөт тундрын ургамалжилтай. Уулсын энгэр, хажууг дагаж хуурай хээрийн ургамалжилт нилээн өгсөж тархдаг. Бэсрэг уулсын ар, хажууг дагаж ботууль, ботууль -жижиг дэгнүүлт үетэнт, үетэн – алаг өвст, уулын бэл хаяагаар хялгана -жижиг дэгнүүлт үетэнт, агь- өдлөг хялганат хээртэй. Голын хөндийг дагасан чацаргана, өргөст харганы ширэнгэ, хус, улиасан төгөлтэй. Хотон, Хурган нуур, Цэнгэл хайрхан голуудын эхний өндөрлөгүүдэд шинэсэн ойтой. Талархаг газраараа өдлөг хялгана – бударганат, өдлөг хялганат, таана өдлөг хялганат, заримдаг сөөгөнцөр – өдлөг хялганат цөлийн хээрийн ургамалжилтай.

Амьтан: Тарвага, бор гөрөөс, цагаан зээр, саарал чоно, үнэг, хярс, шилүүс, мануул, дорго, туулай, чандага, өмхий хүрэн, зурам зэрэг ан гөрөөс элбэг байх ба буга, зэрлэг гахай нилээд байдаг байсан ч ховордсон. Хэрлэн мөрөнд соом, булуу цагаан, зэвгэ, цурхай загас байх ба зарим үед тул загас үзэгддэг.

Түүх соёлын дурсгалд газрууд: Үйл ажиллагаа явуулах төслийн талбайд түүх соёлын дурсгалт газрууд илрээгүй.

Баян Өлгий аймгийн Дэлүүн сумын нийгэм эдийн засгийн үзүүлэлт:

Дэлүүн сумын товч танилцуулга:

Дэлүүн сум нь 1938 оны 6-р сарын 25-ны өдөр анх байгуулагдсан ба аймгийн төвийн баруун өмнө зүгт, нийслэл Улаанбаатар хотоос 1860 км, аймгийн төвөөс 156 км-ийн зайтай оршдог. Нийт газар нутаг нь 559499 га бөгөөд үүнийхээ 530000 га нь бэлчээр, 660 га нь хадлан, 178100 га нь Улсын тусгай хамгаалалттай газар нутагтай.

Алтай, Толбо, Булган сум, Ховд аймгийн Ховд, Дуут сумтай баруун талаараа БНХАУ-тай хил залгадаг. Далайн түвшингээс 1800-4000 м өндөрлөгт оршдог. Сумын нутаг алт, жонш, нүүрс зэрэг байгалийн баялаг ихтэй. Чмхэртэй, Саралахаз, Бузаукөл, Далакөл зэрэг цэнгэг устай нуур, тэрчлэн Буянт гол нь загасаар элбэг Цаг агаарын байдал сэрүүхэн, тогтворгүй, жилийн дундаж температур 0-7 градус, хүйтний улиралд -38 хэм хүртэл хүйтэрдэг. Долдугаар сард +30+33 хэм хүртэл халдаг. Жилд дунджаар 80-100 мм хур тундас ордог. Салхины хурд 26-34м/сек хүрдэг тохиолдол бий. Сумын төв далайн түвшинээс 2160 м өндөрт байрладаг. Ганц мод, Чихэртэй зэрэг голтой. Эдгээр голууд Буянт голд нийлж Хар ус нуурт цутгадаг. Ой мод багатай бөгөөд зарим газарт хар мод, бургас, харгана, ургадаг. Арц, таван салаа, хүнцэл, гаа, зад өвс, хаг өвс, царван зэрэг эмийн ургамал, тошлой хар, улаан хад, зэрэг жимс жимсгэнэ, хялгана, өлөн өвс, хаг өвс, ерхөг, агь, хиа мангир, сонгино зэрэг ургамал элбэгтэй. Буга, янгир, аргаль, угалз, ирвэс, шилүүс, баавгай, чоно, үнэг мануул, нохой зээх, өмхий хүрэн, туулай, булга, тарвага, зурам, хэрэм, үен зэрэг ан амьтан, тас, бүргэд, ёл, хойлог, сойр, шар шувуу, ууль, хэрээ, элээ, болжмор, тагтаа, шаазгай шонхор, тоодог, чуй начин, ятуу, хур, хон хэрээ, зэрэг шувууд нутагладаг, тогоруу, галуу, ангир, нугас, цахлай, хүн, хавтгалж зэрэг усны шувууд хавар ирж, намар буцдаг. Тус сумын нутаг дахь Хөх сэрхийн нуруу бол манай орны томоохон Дархан цаазтай газарт тооцогддог.


Тус сум Засаг Захиргааны нэгж 12 баг болон зохион байгуулагдсан. Газар нутгийн хэмжээ, хүн ам, малын тоогоор Улсад 5-р байрт ордог. Нэг өрхөд дунджаар 98.4 толгой мал ногддог. Сумын ЗДТГ, Ерөнхий боловсролын 1,2,3 дугаар сургууль, Хүүхдийн 1,2,3 дугаар цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв, “Хөх сэрх” ТХГНХЗахиргаа, ус цагуурын станц, Хилийн цэргийн 0135-р салбар, Онцгой байдлын Эрэн хайх, аврах бүлэг, 100 номерийн АТС бүхий холбооны салбар, Халуун ус, Дулааны цахилгаан станц, Хаан банк, Төрийн банк, Мал эмнэлэгийн үйлчилгээний нэгж 8, малчдын бүлэг хоршоо 30 гаруй, ШТС 4,3 ангийн отог, тэжээлийн нөөцийн сангийн салбар, Мешит, Үүрэн холбооны Mobicom, Skytel, Gmobile, Unitel зэрэг 150 гаруй үйлчилгээний цэг бүхий худалдаа үйлчилгээний төв зэрэг аж ахуй нэгж байгууллагуудтай.



Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум

Хүн ам

2024 оны жилийн эцсийн байдлаар 7485 хүн амтай. Нийт хүн амын 44.7 хувь нь 0-19 насны хүүхэд байгаа нь тухайн сум насжилтын хувьд залуужсан хүн амтай сум болохыг харуулж байна. Хөдөлмөрийн насны хүн ам нийт хүн амын 39.6 хувийг эзэлж байна. Дэлүүн сум бол залуу хүн ам давамгайлсан, өсөлтийн нөөц өндөртэй, насжилтын түвшин бага бүс нутаг байна. Ирээдүйд хүн амын өсөлт, боловсрол, хүүхэд хамгаалал, цэцэрлэг сургууль, залуучуудын хөдөлмөр эрхлэлт зэрэгт анхаарах шаардлагатай.



Дэлүүн сумын хүн амын тоо, насны бүлгээр /Эх сурвалж: 1212.mn/

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн байршил, газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Ерөнхий үнэлгээнд төслийн байршилтай холбоотой 4 асуудлыг тодруулах, тэдгээрийн төсөлтэй холбоотой байх шалтгааныг авч үзсэн бөгөөд тэдгээрээс төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна Мөн төслийн үйл ажиллагааны үр дүнд газар нутгийн эмзэг байдлаас шалтгаалж сөрөг нөлөө үүсэх, үүссэн сөрөг нөлөө хуримтлагдаж болзошгүй нөхцлүүд байх боломжтой байна. Төслийн талбайн орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг болон орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар нутаг байхгүй байна.

Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг эсэх гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд орон нутагт хүчтэй салхи шуурга болох магадлалтай, шуурга болсон тохиодолд нөлөөллийн эрчим дунд зэрэг, үер, усны болзошгүй эрсдэлтэй, газрын гадаргыг эвдэж, газрын хэвлийд хоосон орон зай үүсгэх, овоолго үүсгэснээр газрын гадаргад шинээр өндөршил бий болж чулуулагт статик ачаалал үзүүлэх нөлөөлөл байна.

Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд Төслийн үйл ажиллагаа болон орон нутагт хэрэгжиж буй бусад төслийн үйл ажиллагаанаас хам нөлөөлөл үүсч, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг үр дагавар ихтэй богино болон урт хугацааны нөлөөллийг үүсгэхээр байна.

Газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх нөлөөллийн хүрээнд бэлчээрийн газрын гадаргын төрх байдалд өөрчлөлт үзүүлэх нөлөөлөл нь уурхай, баяжуулах үйлдвэрийн талбайн орчимд урт хугацаанд, эрчим ихтэй нөлөөлөл үүсгэхээр байна. Мөн түүнчлэн тус талбайн хөрсний хүнд металл, кемпийн ариун цэврийн байгууламж зэргээс шалтгаалан хөрсөнд микробиологи, нян бактерийн бохирдол үүсэх нөлөөлөл өндөр эрсдэлтэй байна.

3.2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос шороо болон хорт хий агаар орчныг бохирдуулна. Үүнд:

Хөрс хуулах, алт олборлох үед үүсэх тоос

Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтат хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий, дуу чимээ

Уурхайн малталтууд болон овоолгуудын талбайгаас салхинд хийсэх тоос

Хөрс болон элс тээвэрлэх үед техникийн дугуйнаас босох тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болохоор байна.

3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл

Хөрсний морфологи тогтоц алдагдах, үржил шимт нөөц нь багасах, техногений нөлөөлөл ихсэж, зам харгуй үүсч, хөрс эвдрэх, хөрс хийсэх, дарагдах, талхлагдах зэргээр шинж чанар нь өөрчлөгдөх, хөрсний өнгөн хэсэг ахуйн хог болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдох нөлөөллүүд байна. Мөн түүнчлэн баяжуулах үйлдвэрийн

химийн бодис ашиглалтаас шалтгаалан түүний ашиглалтын аюулгүй байдал зэргээс хамааран хөрсөнд бохирдол үүсэх нөлөөлөл их эрсдэлтэй байна.

3.4. Ус нөөц ашиглалт, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уурхай болон үйлдвэр технологийн хэрэгцээний усыг газрын доорх усны нөөцөөс ашиглах ба энэ тохиолдолд газрын доор усны нөөцөд тодорхой хэмжээгээр ашиглалт үүсэх, ундаргын түвшин буурах нөлөөлөл үүснэ. Мөн түүнчлэн уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолтын явцад гүний усыг тэжээдэг мөнх цэвдэг, газрын доорх уст давхаргад нөлөөлөл үүссэнээр уурхайн ухашд шүүрлийн ус үүсэх зэргээр зэргээр газрын гүний усанд үүсэх нөлөөлөл хугацааны хувьд их, эрчмийн хувьд их байхаар байна.

3.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Газарт бууж буй тоос нь ургамлын аль нэг хэсэгт наалдаж улмаар өнгө зүс нь алдагдах, навч шилмүүсэнд нь түлэгдэлт үүсэх, навч нь эрт унах зэрэг байдал бий болдог байна. Ургамлын бүрхүүлийн энэхүү өөрчлөлт нь хүний нүдэнд ил харагдаж байдаг бол үүний цаана нүдэнд харагдахгүй ихээхэн өөрчлөлт орох, фотосинтезийн идэвхи буурах, өсөлт удаашрах улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих нөлөөлөл нь төслийн хүрээнд ашиглах орон нутгийн зам дагуу, бүтээгдэхүүн тээвэрлэлт, уурхайн талбайн ойр орчимд үүсэхээр байна. Мөн уурхайн хөрс хуулалт, бүтээн байгуулалт, барилга байгууламж баригдаж буй хэсгүүдэд ургамлан нөмрөг бүрэн устахаар байна. Энэхүү нөлөөлөл төслийн эхэн үед эрчим ихтэй богино хугацааны нөлөөллийг үүсгэх ба уурхайн дэд бүтцийн барилга байгууламжууд баригдаж дууссаны кемп, баяжуулах үйлдвэрийн газар ашиглалтын хүрээнд орчны тохижилт, ногоон байгууламжийг байгуулах нь энэхүү нөлөөллийг сөрөг нөлөөллийг багасгахад үр дүнтэй байна.

3.6. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл: Барилга бүтээн байгуулалт, уурхайлалтын үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин устах, хөрсөн орчныг шүтэн амьдардаг амьтад үйл ажиллагаанд өртөж үхэж хорогдох, хүний үйл ажиллагааны улмаас амьтдын бүлгэмдэлд өөрчлөлт орох, улмаар зарим зүйл амьтдын тоо толгой, нүүдэл шилжилтэнд сөргөөр нөлөөлөхөөр байна.

3.7. Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уурхайн талбайд археологийн хайгуулын ажлыг анх тус талбайг 2015 онд хайгуулын талбай байх үед Улаанбаатар их сургуулийн Археологийн тэнхимийн хайгуул судалгааны баг хийж гүйцэтгэж байсан. Археологийн хайгуулын судалгааны ажлын дүгнэлтэд дурьдсанаар хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд (одоогийн ашиглалтын талбайн хил нь хайгуулын талбайн хилтэй адил) нийт 39 эртний түүх соёлын дурсгал болох булш оршуулга бүртгэгдсэн.

Палнетологийн хайгуул судалгааны ажлыг мөн 2015 онд МУ-ын Шинжлэх Ухааны Академийн Палентологи-Геологийн хүрээлэнгийн баг хайгуул судалгааны ажлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч Ориент ХХК-ний захиалгаар хийж гүйцэтгэж байсан. Палентологийн хайгуул, судалгааны ажлын дүгнэлтэд энэхүү талбайд үлэг гүрвэл, сээр нуруутны олдворгүй илрээгүй болохыг тодорхойлсон байна.

Дээр дурьдсан археологийн 39 олдвор нь тусгай зөвшөөрлийн талбайн хүрээн дотор байгаа хэдий ч уурхайлалтын ажил явагдах, кемпийн бүтээн байгуулалтын талбайд тухайн булш олворууд давцаагүй байна. Мөн түүнчлэн уурхайн хөрс хуулалт, уурхайн

гүний ахилтын хүрээнд түүх соёлын дурсгалт зүйл илрэх тохиолдолд түүнийг анзаарахгүй өнгөрөх, холбогдох харьяа байгууллагад мэдэгдэх зохицуулалтыг мэдэхгүй, удирдлага зохион байгуулалт бүрдээгүй байх зэргээс шалтгаалан болзошгүй сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй юм.

3.8. Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Улс, орон нутагт тодорхой хэмжээний татвар төлөх, орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд тодорхойлсон ажлууд дээр тусламж дэмжлэг үзүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, сум орон нутагт худалдан авалт эдийн засагт тодорхой хэмжээгээр эерэгээр нөлөөлөх нөлөөлөл байна.

3.9. Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт: Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт “Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”-ийн төслийн үйл ажиллагааны хүрээнд боловсруулагдаж 2026 онд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн хүрээнд тогтоогдсон төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангах, дүйцүүлэн хамгаалал, уурхайн явцын нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнтэй төлөвлөн хийж гүйцэтгэх, төслийн хэрэгжилттэй хүрэн дэх байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийг хангаж ажиллах зорилготой.

2026 онд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр нэн тэргүүнд тавих зорилтот ажлууд нь байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт нийцлийг сайжруулан төслийг холбогдох бичиг баримтын бүрдлийг ханах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг бүрэн хангаж ажиллах зорилт тавин ажиллана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2026 оны Чигэртэй ордын ашиглалтын үйл ажиллагааны бүх үе шатыг хамарна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А-618 журмын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-уудыг тус тус баримталснаас гадна байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурласан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 3-1. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд

Д/д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	10
2	Нөхөн сэргээлт	1
3	Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	2
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	1
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1
6	Осол эрсдлийн менежмент	3
7	Хог хаягдлын менежмент	7
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3
9	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	3
10	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	3

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших “Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”- ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Нийт	38
------	----

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

4.1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4-1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ил уурхайн хөрс хуулалт, хөрсний овоолгын ачилт асгалт хийх үед, технологийн зам гаргах, хүдрийг баяжуулах үйлдвэр лүү тээвэрлэлт хийх зэрэг ажлуудын үед агаар орчинд тоосжилт, хүнд машин механизмаас агаар орчинд хорт хий ялгарах	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх (дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	Уурхайн технологийн зам, хүдэр тээврийн зам	м ³				Тоосжилт их байх дулааны улиралд	Монгол улсын Агаарын тухай хууль MNS4585:2016 Агаарын чанарын стандарт-Техникийн ерөнхий шаардлага
				м ²		1	--*--	Усалгаа хийх шаардлагатай үеүүдэд	
		Замгаас үүсэх тоосжилтыг бууруулах-хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. (хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээг шаардлагатай байршлуудад байрлуулах)	Уурхайн технологийн зам	км		--*--	1500,0	Уурхайн ашиглалтын хугацаанд хэрэгжих	
2	Авто техник хэрэгслээс агаар орчинд хорт хий ялгарах	Тээврийн хэрэгслийг үзлэг оношлогоонд жил бүр тогтмол хамруулах	Уурхайд ашиглагдах техникүүдийн бүрэн хамруулах	ш	30,0	15	450,0	Жилд нэг удаа	
Нийт мян.төг				1950,0					

4.1.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
Хүснэгт 4-2. Гадаргын ба газрын доорхи усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	Газрын доорх усны нөөц ашиглалт	Гүний ус ашиглалтын цооногуудад усны түвшин хэмжигч автомат логгер суурилуулах	Гүний худаг	ш	1000.0	1	1000.0	Тогтмол	MNS0900:2018 Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” - MNS4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар, хаягдал ус. Ерөнхий шаардлага”	
		Гүний ус ашиглалтын худгуудад баталгаат тоолуур суурилуулах	Гүний худгуудад	ш	250.0	3	750.0	Тогтмол		
2	Ус ашиглахтай холбоотой холбогдох хуулийн нийцлийг хангах	Ус ашиглах дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	--*--	Дотоод зардлаар			Жил бүр		
		Нийт мян.төг								1750,0

4.1.3. Хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4-3. Хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үржил шимт хөрс хуулагдах ба хадгалах явцад хөрсний үржил шим өөрчлөгдөх, доройтох ШТМ асгарч орчны хөрсөн бүрхэвчийг бохирдуулах Ахуйн хатуу хог хаягдлаар хөрс бохирдох, орчны эрүүл ахуйн байдал алдагдах	Газарзүйн мэдээллийн системд шимт, шимэрхэг хөрсний овоолгын байршил, хэмжээг бүртгэх, зурагжуулах,	Уурхайн бүс шимт хөрсний овоолго, хаягдлын сан байгуулах талбайн хөрс хуулалт	га/м ³	*	Хөрсний овоолгын хэмжээг зураглах, хэмжилт хийсэн ажлын тайлан	*	Жилийн турш	MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
2		Овоолгыг хаягжуулах		ш	250,00	2	500,0	Жилийн турш	
3		Шимт хөрсний овоолгыг стандартын шаардлагад нийцүүлэн үүсгэх		м ³	Дотоод үйл ажиллагааны зардлын хүрээнд хийгдэх ба хөрс хуулалт, шимт хөрсний овоолго үүсгэх үед байгаль орчны мэргэжилтнээс зааварчилгаа авах, эсвэл шимт хөрсний овоолго үүсгэх зааварчилгаа стандартыг дагаж мөрдөх		Жилийн турш		
4		Олон салаа зам гарган авто замаар хөрс эвдрэхээс сэргийлж нэг замын маршрутаар зорчих, нэг замын маршрутыг батлуулж мөрдөж ажиллах, хяналт тавих, гэрээт байгууллагуудад мөрдүүлэх		км	Дотоод журам, гэрээт байгууллагуудын гэрээнд тусгах				

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших “Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”- ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5		ШТМ хөрсөнд алдагдахаас сэргийлэн техникийн засвар үйлчилгээ хийх талбайг хатуу хучилттайгаар төлөвлөн хийх	Засвар механикийн шопд	л/м ²	Компаний дотоод үйл ажиллагааны зардлаар			Төслийн эхний бүтээн байгуулалтын ажлын хүрээнд	
Нийт мян.төг			500.0						

4.1.4. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн хүрээ хязгаар гадаад овоолго, уурхайн гадаад овоолго зам талбайн хэмжээгээр Ургамлан нөмрөг, бэлчээрийн доройтол үүсэх	Уурхайн кемпд орчны тохижилтын ажлын хүрээнд мод тарилт хийх	Уурхайн кемпэд	ш	10,0	100	1000,0	III болон IV улирал	MNS 6140:2010 Техникийн шаардлага, MNS 6254:2011 Мод, сөөгний суулгацыг бойжуулах. Ерөнхий шаардлага

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших “Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”- ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн ногоон байгууламж мод тарих ажилд дэмжлэг үзүүлэх	Сум орон нутагт	ш	--*--	3500	Орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд		Тэрбум мод
Нийт мян.төг			1000,0						

4.1.5. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн талбай руу татсан цахилгааны шугамд шувуу цахилгаанд цохигдож үхэх, зэрлэг ан амьтдадын бэлчээр нутаг хомсдох	Цахилгаан дамжуулах шугамд шувуу үргээгч байрлуулах	Уурхайн бүс	*	500.0	2.0	1000.0	*	Чигэртэй голын ай савын байгалийн цогцолбор газартай хамтран хэрэгжүүлнэ.
Нийт мян.төг			1000,0						

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 3-2. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Орон нутгаас санал болгосон техникийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай газарт 0,3 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж ажиллана	Сум орон нутагт	га	5,080	0.3	5,080	II болон III улирал	MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5917 : 2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
Нийт мян.төг						5,080			

4.3. Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Чигэртэй голын ай сав Байгалийн цогцолборт газарт Чигэртэй голын эх Булгийн эхийг хашиж хамгаалах		ш	10,0	200	5,000	II болон III улирал	MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5917 : 2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших “Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”- ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
									Техникийн ерөнхий шаардлага
2		Биотехникийн арга хэмжээ авах	Ховор зүйлийн амьтдын зам дагуу	*	500.0	1.0	500.0	I болон II улирал	Тусгай хамгаалалттай газар нутагтай харилцан тохиролцсны үндсэн дээр
Нийт мян.төг			5,500						

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 3-3. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн үйл ажиллагааны хүрээнд нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговрын асуудал	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд давхцал бүхий 6 айлтай нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын талаарх гэрээ байгуулж нөхөн олговрыг өгч ажилласан	Уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд давхцалтай айл өрхүүд	Төслийн үйл ажиллагааны эхэн үед	Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай” журам
Нийт мян.төг			-		

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тусгай зөвшөөрлийн талбайд буй археологийн олдвор булш оршуулга нь	Тусгай зөвшөөрлийн хил хязгаарын хүрээнд илэрсэн археологийн олдвор болох булш нь одоогийн байдлаар уурхайн ашиглалтын болон	Тусгай зөвшөөрлийн хил хязгаарын хүрээнд	*	Дотоод зардлаар		Жил бүр тогтмол хяналт тавьж ажиллана	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших “Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”- ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	уурхайн ашиглалтын талбайд өртөх .	хаягдлын сан байгуулах газрын хил хязгаартай давхцаагүй байна. Уурхайн гүний болон талбайн ахилтын хүрээнд археологи палентлогийн олдвор илрэх үед холбогдох байгууллага болох ШУА-ийн харьяа Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэх арга хэмжээ авна					
Нийт мян.төг			-				

4.6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө
Хүснэгт 3-4. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол эрсдэл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гэнэтийн болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, гал түймэр, үер усны, техникийн осол аваараас шалтгаалан тухайн орчинд бохирдол доройтол үүсэх	Гамшгийн эрсдлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан холбогдох төрийн байгууллагаар хянуулан батлуулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах	Уурхайн ашиглагдаж байгаа техникүүд	4	Үйл ажиллагааны дотоод зардлаар	Тогтмол	Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль	
2								
3	Химийн бодисын ашиглалтын үед үүсэх сөрөг нөлөөлөл	Химийн бодисын болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүнд: удирдлага зохион байгуулалтын үед химийн	Уурхайн бүтэц зохион байгуулалтын хүрээнд	*	Үйл ажиллагааны дотоод зардлаар	Тогтмол	Химийн хорт бодис аюултай бодисын тухай хууль	

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших “Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”- ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		бодисын ашиглалтын үеийн хяналт тавих бүтэц зохион байгуулалтыг тодорхойлох					
4		Асгаралтын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах батлуулж хэрэгжүүлэх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд ашиглах	*			
Нийт мян.төг			---*				

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3-5. Хог хаягдлын менежмент төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Уурхайн ойр орчимд гадна орчны цэвэрлэгээг хийх	Уурхайн бүс	удаа	---*	---*	---*	Шаардлагатай тохиолдолд	Хог хаягдлын тухай хууль
2		Хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулах уурхайн кемпэд ангилан ялгах зориулалттай хогийн сав байршуулах,		ш	2000.0	1.0	2000.0	Тогтмол	
3									
4									
5		Энгийн хог хаягдлыг сум орон нутагтай гэрээ байгуулан хогийн цэгт тээвэрлэнэ.		Энгийн хог хаягдлыг цуглуулан тээвэрлэсэн тоо давтамж	Дотоод зардлаар		Тогтмол		Хог хаягдлын тухай хууль
6	Аюултай хог хаягдал	Техникийн ашигласан тос маслыг шаардлага хангасан нөхцөлд түр цуглуулан, мэргэжлийн байгууллагад гэрээний үндсэн дээр нийлүүлэх	Аюултай хог хаягдал цуглуулах талбай	Аюултай хог хаягдал үүсэх бүсд	Гэрээний үндсэн дээр		Үйл ажиллагааны явцад		
7		Аюултай хог хаягдлыг нийлүүлэгч болон гэрээт компанид нийлүүлэх			Гэрээний үндсэн дээр				

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших “Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”- ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
8		Аюултай хог хаягдлын дагалдах бичиг, бүртгэлийг тогтмол хөтлөх						Дотоод зардлаар	Тогтмол
9		Аюултай хог хаягдлыг нэр, төрөл бүрээр бүртгэх	Уурхай, засвар механикийн хэсэг	Бүртгэл, тоо хэмжээ		--*--		Тогтмол	
Нийт мян.төг			2000.0						

4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 3-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Хугацаа давтамж	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
АГААРЫН ЧАНАР							
1	Агаарын бохирдлын шинжилгээ SO ₂ , NO ₂ , CO ₂	2	1. Ил уурхайн хөрс хуулалтын орчимд, 2. Баяжуулах үйлдвэрийн хүдэр буулгах хэсэгт, 3. Хог хаягдлын цэг орчимд 4. Нам даралтын уурын зуух орчимд (байгаа тохиолдолд зөвхөн галлагааны үед)	Жил бүрийн II, IV улиралд, хөндлөнгийн хяналтаар 2 удаа	150.0	600.0	<ul style="list-style-type: none"> • Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2016 • MNS 3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага, • MNS 5061:2001. Нүүрс Хүчлийн хий-CO₂ тодорхойлох эзэлхүүний арга, • MNS 0012-1-015:1987. Чимээ шуугиан–Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга, • MNS0017.2.5.11-1998. Азотын давхар исэл
2	Агаарын тоос тоосонцорын мониторинг (TSP, PM ₁₀ , PM _{2.5})	3			100.0	600.0	
3	Дуу шуугианы хэмжилт мониторинг	3			100.0	600.0	
Агаар орчны хяналт шинжилгээний нийт зардал					1800.0		

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших “Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”- ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Хугацаа давтамж	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
УСАН ОРЧИН							
1	Усны ерөнхий хими физикийн шинжилгээ үүнд дараах нэгдлүүдийн агууламжийг тодорхойлно: <ul style="list-style-type: none"> - рН - өнгө - Ca²⁺, Mg²⁺кальци магнийн нийт агууламж, - NH⁺ аммони, - Na⁺+K⁺натри кали, Fe³⁺төмөр, - SO₄²⁻сульфат, - HCO₃- карбонат, - Cl- хлор, - NO₂⁻ нитрит, - NO₃⁻ нитрат) 	3	Технологийн 3 худаг	Жил бүрийн II, IV улиралд, хөндлөнгийн хяналтаар	200.0	600.0	<ul style="list-style-type: none"> • Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 900: 2018 • Усны тухай хууль • MNS 6148:2010 Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт MNS 4943:2008 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
2	Микробиологи, бактериологийн шинжилгээ (нийт нянгийн тоо, гэдэсний бүлгийн нян, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян	2	Унд ахуйн усны гаралтын шугамаас, цэвэр усны нөөцийн сав	Жил бүрийн II, IV улиралд, хөндлөнгийн хяналтаар	100.0	200.0	
Усан орчны хяналт шинжилгээний нийт зардал					800.0		
ХӨРСӨН БҮРХЭВЧ							
1	Хөрсний хими, физик ерөнхий шинж (рН, давс, ЦДЧ, Ялзмагийн агууламж, CaCO ₃ , хөрсний механик бүрэлдэхүүн)	3	Хөрсний овоолго олборлолтын талбайн орчим, ШТС, хог хаягдлын цэг орчим	Жил бүрийн II, IV улиралд, хөндлөнгийн хяналтаар	80.0	480.0	<ul style="list-style-type: none"> • Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019 • Хөрсний шинжилгээний дээж авах ерөнхий шаардлага MNS

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших “Чигэртэй нэртэй ордын зэс алтны хүдрийн биетийг ил болон далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”- ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Хугацаа давтамж	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Хүнд металл	5	ШТС, засвар үйлчилгээний цэг, хогийн цэг, Хаягдлын сангийн байгууламж орчимд, Хөрсний овоолго		100.0	1000.0	3298:1990 • MN2305: 1995 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам. • MNS 6341: 2012 Хөрсний чанар. Хөрсөнд эрүүлзүйн нян судлалын шинжилгээ хийх арга • MNS 5367 : 2004 Хөрс. Гэдэсний бүлгийн нян, гэдэсний бүлгийн халуун даадаг нян болон байж болох E.Coli-г илрүүлэх арга
3	Микробиологи, бактериологийн шинжилгээ (нийт нянгийн тоо, гэдэсний бүлгийн нян, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян)	2	Хогийн цэг, бохирын септик орчим		100.0	400.0	
Нийт мян.төг					1880.0		
УРГАМЛАН НӨМРӨГ							
1	Ургамлын төрөл, зүйл, бүрхэц, түүний хомсдолт, доройтлын зэрэглэл, төрөл зүйлийн тоо, дундаж өндөр, биомасс	4	Уурхайн хөрс хуулалт явагдах талбайн ойр орчимд, хаягдлын сангийн барилга байгууламж баригдах талбайн ойр орчимд, кемпийн ойр орчимд, уурхайн кемп орчмын зам дагуу	Жил бүрийн II, IV улиралд, хөндлөнгийн хяналтаар – мэргэжлийн ургамал судлаач дүгнэлт үр дүн	400.0	1600.0	MNS 5546:2005 Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхагдлыг тогтоох ерөнхий шаардлага.
2	Ургамлын мониторинг тогтмол хийх цэгүүдийг тогтоох			Үйл ажиллагааны хүрээнд дотооддоо хийх			
Ургамлан нөмрөгийн хяналт шинжилгээний нийт зардал					1600.0		
Орчны хяналт шинжилгээний ажлын нийт зардал					6080.0		

4.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 3-7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв мян.төг	Хариуцсан албан тушаалтан
1	- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлж ажиллах удирдлага зохион байгуулалтаар хангах, холбогдогдох ажлын төсөв зардлыг шийдвэрлэн төлөвлөсөн хугацаанд ажлын гүйцэтгэлийг хангах, - Биелэлтийн тайланг жил бүр хуулийн хугацаанд байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх	Дотоод зардлаар	Удирдлага зохион байгуулалт
2	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд шаардлагатай зардал төсвийг батлан хэрэгжилтэнд хяналт тавих (нийт байгаль орчныг хамгаалах талаар хийгдсэн ажлын зардлын баримт)	Дотоод зардлаар	
3	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын барьцаа төлбөрийг байршуулах	Дотоод зардлаар	
Нийт мян.төг		--*--	

4.10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 3-8. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ-ний биелэлтийг оролцогч талуудад тайлагнах	Тайлагнах хэлэлцүүлэх	Мэдээний агуулга	Хугацаа	Зохион байгуулах газар	Төсөв мян.төг
1	Баян-Өлгий аймгийн БОАЖГ	Илтгэл	Тухайн жилийн БОМТ-ний биелэлт	Жил бүрийн 11 сард	Уурхайн талбайд, аймгийн Байгаль орчны газарт	500.0
2	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын иргэд, байгаль хамгаалагч	Илтгэл	Тухайн жилийн БОМТ-ний биелэлт	Жил бүрийн 11 сард	Баян-Өлгий аймаг Дэлүүн сум	500.0
3	Дэлүүн сумын байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагчид шаардлагатай мэдээ тайланг хүргүүлэх	Танилцуулга	Мэдээ тайлангууд	Сар бүр	Баян-Өлгий аймаг Дэлүүн сум	Дотоод зардлаар
Нийт мян.төг				1000.0		

4.11. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардал
Хүснэгт 3-9. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Зардлын утга	Нийт зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	6,200
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал	5,080
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	5,500
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний зардал	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	-
7	Хог хаягдлын менежментийн зардал	2,000
8	Орчны хяналт шинжилгээний ажлын зардал	6,080
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал	--*-
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний зардал	1,000
Нийт зардал мян.төг		25,860

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө **12,930,000** төгрөгийг нөхөн сэргээлтийн барьцаанд байршуулахаар байна.